



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 7.1 дэх заалт, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Дархан Детект ХХК-ийн эмнэлгийн (РД:4251172) оноосон нэр Сөүл Мед Нетворк ХХК-ийн эмнэлэг болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан батламжийн нэрийг сольж, батламжийн дугаар болон хүчинтэй хугацааг өмнөх батламжийн дугаар, хугацаагаар олгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260213

Эрүүл мэндийн сайдын  
2026 оны 02 сарын 02 ны өдрийн  
Д/36.. дугаар тушаалын хавсралт

**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Юнимед интернейшнл ХХК-ийн эмнэлэг	10/2026	2 жил	2026.01.31	2028.01.31
2.	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	11/2026	3 жил	2026.02.07	2029.02.07
3.	Хийлс-Эйд ХХК-ийн эмнэлэг	12/2026	1 жил	2026.01.30	2027.01.30
4.	Увс аймаг, Увс-Мөнхтэнгэр ХХК-ийн Жаргалан эмнэлэг	13/2026	2 жил	2026.02.05	2028.02.05